


## Level: Ecolier

(Монгол улсын ЕБС-ийн 3-4-р анги)

### 3 онооны бодлогууд:


1) Цэцэрлэгт хүрээлэн 1 метр талтай квадратуудаас тогтоно. Цэцэрлэгт хүрээлэнд туулайны явсан замыг дүрслэв. Тэгвэл туулай хэдэн метр явсан бэ?

- A) 18 метр      B) 19 метр  
C) 20 метр      D) 21 метр  
E) 22 метр




2) Кенгуру хаана байгааг олоорой.


- A) Тойрог дотор, квадратын гадна.  
B) Тойрог дотор, квадратын дотор.  
C) Квадратын дотор, тойргийн гадна.  
D) Тойргийн гадна ба квадратын гадна.  
E) Тойргийн дотор биш ба квадратын дотор.



3) Саруул жижиг кубууд ашиглан нэгэн том куб өржээ. Уг кубыг баруун талд үзүүлсэн байна. Дараа нь тэр хэдэн жижиг куб хасаж зүүн талд байгаа биетийг үүсгэв. Тэгвэл Саруул хэдэн жижиг куб хассан бэ?




- A) 6      B) 8      C) 10  
D) 12      E) 14



4) Дэлгэцэн дээр 930 гэсэн тоо байна (зураг хар). 806 гэсэн тоо болгон өөрчлөхийн тулд хэдэн ширхэг (гэрлэн) нүд өөрчлөх хэрэгтэй вэ?


- A) 6      B) 8      C) 10      D) 12      E) 14



5) Ээж 16 дэвтэр худалдан авав. Батад хагасыг нь, Дулмаад хоёр дэвтэр өгч үлдсэнийг нь Даваад өгчээ. Ээж хэдэн дэвтэр Даваад өгсөн бэ?

- A) 4      B) 6      C) 8      D) 10      E) 12

6) Алдар хашаандаа  $10 \times 20$  см хэмжээтэй 10 ширхэг тоосгон хавтан ашиглан явган хүний зам засчээ. Ингэхдээ тоосгонуудыг гол хэсгээр хар зураас гарган будав (зураг хар). Энэ хар зураасны уртыг ол?



- A) 70 см B) 90 см C) 140 см D) 150 см E) 180 см

7) Сарнай шоог дөрвөн удаа орхиход нийт буусан нүднүүдийн нийлбэр нь 23 байжээ. Тэгвэл “6 нүд” хэдэн удаа буусан бэ?

- A) 0 B) 1 C) 2 D) 3 E) 4

8) Кино 90 минут үргэлжилдэг. 17:10 цагт эхлээд дундаа хоёр удаа завсарлажээ. Эхний завсарлага 8 минут, хоёрдугаар завсарлага 5 минут байсан бол кино хэдэн цагт дууссан бэ?


- A) 18:13цагт B) 18:27цагт C) 18:47цагт D) 18:53цагт E) 19:13 цагт

#### 4 онооны бодлогууд:

9) Бүжгийн дугуйлан 25 хүү, 19 охинтой байв. Долоо хоног бүр хөвгүүдийн тоо 2-оор, охидын тоо 3-аар нэмэгддэг. Хэдэн долоо хоногийн дараа охид ба хөвгүүдийн тоо тэнцүү болох вэ?

- A) 6 B) 5 C) 4 D) 3 E) 2

10) Шоколадны нүднүүд ижилхэн хэсгүүдээс тогтоно. Ганаа шоколад хуваав. Ингэхдээ эхлээд 5 нүдтэй нэг эгнээг ахдаа, дахин 7 нүдтэй нэг эгнээг эгчдээ өгчээ (зурагт үзүүлсэний дагуу). Тэгвэл нэг бүтэн шоколад хэдэн нүдтэй вэ?



- A) 28 B) 32 C) 35 D) 40 E) 54

11) Соёолон, хязаалан хоёр нийлээд 320кг жинтэй. Соёолонгийн жин хязаалангынхаас 32кг-аар илүү бол хязаалангийн жинг ол.


- A) 128кг B) 144кг C) 160кг D) 176кг E) 192кг

12) Тэгш өнцөгтийн нэг тал нь 8см, нөгөө тал нь энэ талынхаа хагастай тэнцүү. Тэгвэл энэ тэгш өнцөгтийн периметртэй адил периметртэй квадратын талын урт хэд байх вэ?

- A) 4 см      B) 6 см      C) 8 см      D) 12 см      E) 24 см

13) Төгөлдөр шоонууд ашиглан ширээ хийжээ (зураг хар). Түүний хийсэн ширээнд хэдэн шоо орсон бэ?



- (A) 24      (B) 26      (C) 28      (D) 32      (E) 36



14) Цүндээлэй, Цондоолой, Цодгор гурав нийлээд 7 сагс мөөг түүжээ. Тэд өөр өөр тооны сагс мөөг түүсэн ба Цүндээлэй хамгийн бага, Цондоолой хамгийн олон сагс мөөг түүсэн бол Цодгор хэдэн сагс мөөг түүсэн бол?

- A) 1      B) 2      C) 3      D) 4      E) тодорхойлох боломжгүй

15) Баруун талд байгаа хоёр даалуугаар аль дүрсийг үүсгэж чадахгүй вэ?



### 5 онооны бодлогууд:

16) Хашаан дотор 30 туулай, хэдэн тахиа байжээ (өөр амьтан байхгүй). Тахиануудын хөлийн тоо нь туулайнуудын хөлийн тоотой тэнцүү байв. Тэгвэл хашаанд нийт хэдэн амьтан байсан бэ?

- A) 60      B) 90      C) 120      D) 180      E) 240

17) Анна, Гаадан хоёр нэг гудамжинд амьдардаг. Аннагийн гэрээс нэг тийш 27 айл, нөгөө тийш 13 айл байдаг. Харин Гаадангийн гэр энэ гудамжны яг дунд нь байдаг. Тэгвэл Аннагийн гэр, Гаадангийн гэр хоёрын дунд хэдэн айл байгаа вэ?

- A) 6      B) 7      C) 8  
D) 14      E) 21



---

18) Тагнуулч зургаан оронтой код тайлах болов. Түүнд тэгш оронд буй цифрүүдийн нийлбэр нь сондгой оронд буй цифрүүдийн нийлбэртэй тэнцүү гэсэн мэдээлэл бий. Дараах тоонуудаас аль нь дээрх мэдээлэлд тохирох вэ?

(A) 81\*\*61 (B) 7\*727\* (B) 4\*4141 (Г) 12\*9\*8 (Д) 181\*2\*

---

19) Мягмар алдартай тамирчдын зураг цуглуулдаг. Жил бүр түүний цуглуулсан зургийн тоо нь, өмнөх хоёр жилд цуглуулсан зургийн тооны нийлбэртэй тэнцүү. Тэр 2008 онд 60 зурагтай байсан ба энэ жил (2009 онд) 96 зурагтай. Тэгвэл Мягмар 2006 онд хэдэн зураг цуглуулсан байсан бэ?

A) 20 B) 24 C) 36 D) 40 E) 48


---

20) Сагсанд 1 улаан, 1 хөх, 1 шар, 1 цагаан цэцэг байв. Зөгий сагсанд байгаа цэцэг бүр дээр нэг л удаа суудаг. Зөгий хамгийн эхлээд улаан цэцгэн дээр суусан ба тэр шууд шар цэцэгнээс цагаан цэцэг рүү нисээгүй. Зөгий бүх цэцгэн дээр суухдаа хэдэн янзаар очиж болох вэ?

A) 1 B) 2 C) 3 D) 4 E) 6

---

21) Жижиг робот 1 см яваад зогсож дараагийн команд хүлээнэ. Хэрэв ♥ команд өгвөл баруун, харин ♠ команд өгвөл зүүн тийш эргэнэ. Хэрэв ♥♠♠♠♥♥ команд өгвөл робот ямар зам үүсгэн явах вэ?



---

22) Нэгэн арал дээр амьдардаг хүмүүсийн эрэгтэй хүн бүрийн зүүн хөл нь баруунаасаа 2 размер том, харин эмэгтэй хүн бүрийн зүүн хөл нь баруунаасаа 2 размер том гутал өмсдөг гэнэ. Гэвч гуталын дэлгүүр ижил размерын гутал зардаг. Хэсэг найзууд мөнгөө хэмнэхийн тулд бүгдээрээ хамтдаа гутал худалдаж авчээ. Тэд гутлаа өмсөхөд бүгдэд нь таарсан ба нэг 36, нэг 45 размерын хоёр гутал үлджээ. Гутал авсан хүмүүсийн тоо хамгийн багадаа хэд байх боломжтой вэ?

A) 5 B) 6 C) 7 D) 8 E) 9

---